

“СҮҮ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12-р сарын 03-ны өдөр

№ 23

Улаанбаатар хот

СҮҮ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИД, ХАРИЛЦАГЧДАД ХУВЬЦАА ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.13 дахь хэсэг болон 2021 оны 12 сарын 03-ны өдрийн “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хамтран ажиллаж буй сүү бэлтгэн нийлүүлэгчид, харилцагчдыг хувьцаажуулах хөтөлбөр”-ийн нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.

2. Компанийн хөтөлбөрт хамрагдах хамтран ажиллаж буй сүү бэлтгэн нийлүүлэгчид, харилцагчдын жагсаалтыг батлахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д зөвшөөрсүгэй.

3. “Хамтран ажиллаж буй сүү бэлтгэн нийлүүлэгчид, харилцагчдыг хувьцаажуулах хөтөлбөр”-т хамрагдах сүү бэлтгэн нийлүүлэгчид, харилцагчдад 500,000 ширхэг хүртэлх энгийн хувьцаа олгож, холбогдох ажлыг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор эцэслэн дуусгахыг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д даалгасугай.

4. Хөтөлбөрийн болзол хангасан, жагсаалтад багтсан хамтран ажиллаж буй сүү бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдын худалдан авах хувьцааны үнийн дүнг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн тухайн өдрийн зах зээлийн ханшаар тооцон, арилжааны шимтгэлийг тус мөнгөн дүнгээс суутгах зохицуулалттайгаар хамтран ажиллаж буй сүү бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдын үнэт цаасны дансанд шилжүүлэхийг Санхүүгийн албаны дарга /Э.Уянга/-д, Гүйцэтгэх захирал /М.Болод/-д тус тус зөвшөөрсүгэй.

5. Компанийн “Хамтран ажиллаж буй сүү бэлтгэн нийлүүлэгчид, харилцагчдыг хувьцаажуулах хөтөлбөр”-тэй холбоотой ажлыг зохион байгуулах, түүнтэй холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах, төлбөр тооцоог хийхийг Гүйцэтгэх захирал /М.Болод/-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР

"Сүү" ХК-ийн 2021 оны 12 сарын 03-ны өдрийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
23 тоот тогтоолын Хавсралт №1



"Хамтран ажиллаж буй сүү бэлтгэн нийлүүлэгчид, харилцагчдыг хувьцаажуулах хөтөлбөр"-т хамрагдах нөхцөл

1. Тогтмол сүү нийлүүлж буй 2020 онд 1 тонноос дээш хэмжээний сүү нийлүүлсэн бэлтгэн нийлүүлэгчийн 2020 онд нийлүүлсэн 108 литр сүү тутамд 1 ширхэг энгийн хувьцаа олгох.
2. Фермийн үйл ажиллагаа эрхэлдэггүй дамжуулан борлуулагчийн 2020 онд нийлүүлсэн 1 тонн сүү тутамд 1 ширхэг энгийн хувьцаа олгох.
3. Компаниас баталсан жагсаалтад багтсан харилцагчдаас 2020 онд татан авсан Сүү ХК-ийн бүтээгдэхүүний НӨАТатвар багтаагүй үнийн дүнд суурилан дор дурдсан шатлалаар энгийн хувьцааг олгоно. Үүнд:

№	Шалгуур	Урамшуулах энгийн хувьцааны тоо /Ширхэг/
1	500 сая ₮-с дээш	3,000
2	300-500 сая ₮	2,000
3	100-300 сая ₮	1,000
4	90-100 сая ₮	900
5	80-90 сая ₮	800
6	70-80 сая ₮	700
7	60-70 сая ₮	600
8	50-60 сая ₮	500
9	40-50 сая ₮	400
10	30-40 сая ₮	300
11	20-30 сая ₮	200
12	10-20 сая ₮	100
13	10 сая ₮-с доош	50

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д. ГАНБААТАР